



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 418


Улаанбаатар хот

Иргэдэд газар эзэмших эрх
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны А/40 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Шинээр газар эзэмших хүсэлт ирүүлсэн 22 (Хорин хоёр) иргэнд гэр бүлийн хэрэгцээнд зориулан, газар эзэмших эрхийг олгож, хавсралтаар баталсугай.
- 2.Газар эзэмших эрх олгогдсон иргэдтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, Улсын бүртгэлд бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд даалгасугай.
- 3.Холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, газрыг зориулалтын дагуу зөв зохистой эзэмшихийг хавсралтад нэр заагдсан иргэдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

АЖИЛ 2024 он ажил захирамж

1123200021